



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 29 өдөр

Дугаар А/817

Эрдэнэт

Ариутгалын бодисын нөөц бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3/а/, 29.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 13 дүгээр зүйлийн дүгээр зүйлийн 13.7, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 240 дугаар тогтоолын хавсралт 2.3.2, 4.2.1, 4.2.5 дахь заалт, ИТХ-ын 2017 оны IX хуралдааны II тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд ариутгалын бодисын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний бэлэн байдлыг хангах, ариутгалын бодисын нөөц бүрдүүлэхийг Хүнс хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/-т үүрэг болгосугай.

3.Ариутгалын бодисын нөөц бүрдүүлэхэд шаардагдах 2793600 /Хоёр сая долоон зуун ерөн гурван мянга зургаан зуун/ төгрөгийг "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр"-ийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэгт/-т зөвшөөрсүгэй.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч С.Батжаргалд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын
25 өдрийн 277 дугаар захирамжийн хавсралт



АРИУТГАЛЫН БОДИСЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХЭД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Бүгд үнэ /төг/	Тайлбар
1	Хлорын шохой	кг	200	5500	1100000	Халдварт өвчний халдварын голомт болон малын сэг зэм устгах ариутгалын бодис
2	HI-COP	кг	60	25000	1500000	Халдварт өвчний халдварын голомт болон малын сэг зэм устгах ариутгалын бодис
3	Тээврийн зардал шатахуун	л	97.5	1985	193600	Ариутгалын бодис татах
	Дүн				2793600	